



ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ, ШИЛЖИЛГТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/279

Улаанбаатар хот

Зөвлөмжийг хэрэгжүүлж, ажил
үүрэг хариуцуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.8, 6.6, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 9 дүгээр зүйлийн 9.2, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2-д заасныг тус тус үндэслэн, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2015 оны 5/7436 тоот зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Ерөнхий газар болон Орон нутаг дахь газарт авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, бичгээр зөвлөмж өгөх, ашиг сонирхлын зөрчлөөс болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг Ерөнхий газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж /Х.Баярхүү/, Орон нутаг дахь газарт тус тус хариуцуулсугай.

2. Байгууллагын нийт нийтийн албан тушаалтнаас холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журамд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрт нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар болон өөрийн хамаарал бүхий этгээд хийгээд нэгдмэл сонирхолтой этгээдийн зүгээс аливаа хэлбэр /бэлэг, хандив, авлига, ашиг хонжоо, давуу байдал, албан тушаалын эрх мэдэл, эс үйлдэл/-ээр үзүүлэх нөлөөлөл болон олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц этгээд /өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг/-тэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулбал уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, тухай бүр нь Байгууллагын дарга, эсхүл эрх бүхий байгууллагад, хариуцлага хүлээлгэхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэж байхыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Энэ тушаалд заасан нөхцөл байдал илэрсэн тохиолдолд дор дурдсан ажиллагааг дараах албан тушаал, нэр бүхий албан хаагч нар тус тус хариуцан ажиллахыг үүрэг болгосугай:

а/ Ажилд авах, ажлын байрны тодорхойлолт, эрхлэх асуудлын чиг үүрэгт нь өөрчлөлт орсны улмаас шилжүүлэн болон сэлгэн томилох, туршилтын хугацаагаар болон Төрийн албаны тухай хуулийн хүрээнд тухайн албан тушаалын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилох болсон тохиолдол бүрт тухайн нэр дэвшигчийг томилохын өмнө "хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлэг"-ийг авч хүргүүлж байхын хамт эдгээрийг хянан шалгах явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулж байхыг Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжийн дарга /Х.Баярхүү/, мэргэжилтэн /Ч.Нармандах, Н.Дуламжав, П.Амаржаргал, Ч.Заяажаргал/ нарт;

б/ Тушаал гаргах бүрт Захиргааны ерөнхий хуулийн 29.2-т заасны дагуу түүнийг боловсруулахад оролцсон албан хаагч нэг бүрээр "хяналтын дагалдах хуудас"-т гарын үсэг зуруулах үед "Ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх /зөрчил үүссэн тухай/ мэдэгдэл"-ийг гаргуулан авч байхыг Ерөнхий газрын хуулийн мэргэжилтэн /М.Уранбилэг, Ч.Өсөхбаяр/ болон Орон нутаг дахь газрын дарга нарт;

в/ Удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах асуудлыг бэлтгэх, хэлэлцэх бүрийн өмнө Даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд оролцогч нэг бүрээс "Ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх /зөрчил үүссэн тухай/ мэдэгдэл"-ийг гаргуулан авч байхыг Ерөнхий газрын нууцын эрхлэгч /А.Мөнгөн/ болон Орон нутаг дахь газрын дарга нарт;

г/ Оршин суух зөвшөөрөл олгох, сунгах, татгалзахтай холбоотой болон гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэхтэй холбоотой асуудлыг бэлтгэх, хэлэлцэх бүрийн өмнө "Оршин суух зөвшөөрлийг хянан шийдвэрлэх мэргэжлийн зөвлөл"-ийн хуралдаанд оролцогч нэг бүрээс "Ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх /зөрчил үүссэн тухай/ мэдэгдэл"-ийг гаргуулан авч байхыг Зөвшөөрөл, бүртгэлийн асуудал хариуцсан нэгжийн дарга /С.Хүдэрчулуун/, Иргэний харьяалалын асуудал хариуцсан нэгжийн дарга /А.Энх-Эрдэнэ/ болон Иргэний харьяаллын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн /Ч.Үржинханд, Г.Мөнхгэрэл, Т.Соёл-Эрдэнэ/ нарт;

д/ Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийх болон ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл, мэдэгдлийг хүлээн авах, түүний дагуу шалгах, хариуцлага хүлээлгэхийн өмнө уг арга хэмжээнд оролцогч нэг бүрээс "Ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх /зөрчил үүссэн тухай/ мэдэгдэл"-ийг гаргуулан авч байх, хяналт шалгалтын явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулж байхыг Хяналт-шинжилгээ, аудитын асуудал хариуцсан нэгжийн дарга /Б.Мөнх-Оргил/, Хяналт, шалгалт хариуцсан нэгжийн дарга /Х.Бэхбат/ болон Орон нутаг дахь газрын дарга нарт;

е/ Зорчигч, тээврийн хэрэгслийг Монгол Улсын хилээр нэвтрэхэд баримт бичиг, визийн шалгалт явуулахын өмнө уг арга хэмжээнд оролцогч-шалгагч нэг бүрээс "Ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх /зөрчил үүссэн тухай/ мэдэгдэл"-ийг гаргуулан авч, хяналт шалгалтын явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулж байхыг Шалган нэвтрүүлэх асуудал хариуцсан нэгжийн дарга /Г.Ганбат/, Орон нутаг дахь газрын дарга нарт;


ё/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулахад оролцох, гэрээ байгуулах бүрт "Ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх /зөрчил үүссэн тухай/ мэдэгдэл"-ийг гаргуулан авч байхыг Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн дарга /Д.Мөнгөнцэцэг/, Хангалт, үйлчилгээний асуудал хариуцсан нэгжийн дарга /Ц.Ганбат/, Орон нутаг дахь газрын дарга нарт.

4. Эдгээр мэдэгдлүүдийг гаргуулан авахдаа мэдүүлэг нэг бүрийг бүртгэн авч, дүнг улирал, бүтэн жилээр нэгтгэн гаргаж Ерөнхий газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлж байхыг дээрх ажиллагааг хариуцан ажиллаж буй дээрх албан тушаал, нэр бүхий албан хаагчдад, энэхүү дүн мэдээг нэгж бүрээр тооцон нэгтгэж, заасан хугацаанд Байгууллагын даргад танилцуулан холбогдох арга хэмжээг авч, дүн мэдээ, материалыг жилийн эцэст Ерөнхий газрын архивын сан хөмрөгийн эрхлэгч /Т.Баасанжав/-д шилжүүлэн хадгалуулж байхыг Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж /Х.Баярхүү/-д тус тус даалгасугай.

5. Энэ тушаалын 3-т заасан албан тушаал, нэр бүхий албан хаагчдын албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтод дээрх үүргийг нэг бүрчлэн тусгаж, баталгаажуулахыг Ажлын байрны тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг /Х.Баярхүү/-т даалгасугай.

6. Ерөнхий газрын үйлчилгээний танхимын дугаар дуудах болон бусад үйлчилгээний ил тод, шуурхай ажиллагааг хангах ажлыг хариуцан ажиллаж байхыг Зөвшөөрөл, бүртгэлийн асуудал хариуцсан нэгжийн ахлах мэргэжилтэн /Д.Төрхүү, Г.Ганчимэг, Г.Ганзаяа/ нарт хариуцуулсугай.

7. Энэ тушаалыг Ерөнхий газрын цахим хуудаст байршуулж, хувийг Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлэхийг Ерөнхий газрын олон нийттэй харилцах ажилтан /Т.Сэлэнгэ/-д, нийт албан хаагчдад мэдээлж, биелэлтэд хяналт тавин ажиллах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29.2, 29.3-д заасны дагуу буруутай этгээдэд сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг тухай бүрт нь танилцуулж, үр дагавар, шалтгаан, нөхцлийг нь арилгах, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг холбогдох байгууллагад хүргүүлж байх зэрэг удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Г.Төгөлдөр/-т тус тус даалгасугай.

ДАРГА  Д. БОЛД